

эрсдэл бүхий бараа тээврийн хэрэгсэлд анхаарал хандуулах замаар гаалийн байгууллагын санхүү, техник, хүний нөөцийг зөв хуваарилах, гаалийн хяналт, шалгалтын үр ашиг нэмэгдэнэ.

7. ИААН-д тавигдах шалгуур:

| | | |
|-----------------------------|---------------------|-------------------------|
| Дотоод хяналтын систем; | Санхүүгийн чадавхи; | Хууль сахиултын түвшин; |
| Аюулгүй байдлын шалгуурууд. | | |

8. Гаалийн байгууллагаас үзүүлэх хөнгөлөлт:

| | | |
|---|--|--|
| Гаалийн бүрдүүлэлтийг хөнгөн, шуурхай хийх; | Байр, агуулахад гаалийн бүрдүүлэлт хийх; | Цахим, цаасгүй бүрдүүлэлт; |
| Барааг ИААН-ийн өөрийнх нь агуулахад түр хадгалахыг зөвшөөрөх; | Барааг ИААН-ийн өөрийнх нь агуулахад шалгах; | Онцгой тохиолдолд бараа, тээврийн хэрэгслийг бичиг баримтын болон биет шалгалтаас чөлөөлөх; |
| Зарим тохиолдолд барааг тогтмол хугацаагаар мэдүүлэхийг зөвшөөрөх; | ИААН нь худалдааны найдвартай түнш гэдгийг нийгэд зарлан мэдээлэх; | ИААН-ийн хөтөлбөрийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Хэлэлцээр байгуулсан улсуудад давхар хөнгөлөлт эдлэх; |
| Гаалийн байгууллагаас албан тушаалтан томилох; | Компанийн дотоод үйл ажиллагаа сайжирна. | Өрсөлдөхүйц, нэр хүндийн баталгаа; |
| ИААН-ийн байр агуулах, талбайд барааг боловсруулалт хийх гаалийн горимын хэрэгжүүлэх; | Гаалийн болон бусад татвар төслтийг хойшлуулах; | |

Танд лавлах зүйл байна уу!



1800-1281

Гааль сонсож байна



Талархал



Гомдол



Асуулт



Санал

ГААЛИЙН ЛАВЛАХ УТАС

Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авах, гаалийн хууль тогтоомж, заавар, журам, гаалийн үйлчилгээний талаар мэдээ, мэдээллээр хангах, сан бүрдүүлэх зорилгоор “Гаалийн лавлах-1281” нээлттэй утас ажиллуулж байна.

Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаархи иргэд, байгууллагын асуултуудыг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган мэдээлэл, гомдол саналын мөрөөр шаардлагатай арга хэмжээ авах, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл, зөвлөлгөө өгөх, сурталчилгаа хийх болон гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.



Хаяг:
Сүхбаатар дүүрэг, "Их тойруу-81/1",
Улаанбаатар-14193, Монгол Улс
Утас: (976-11) - 351986; 70130070
Факс: (976-11) - 350048
E-mail: info@customs.mn
Интернет: http://www.customs.gov.mn



МОНГОЛ УЛСЫН
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР


ГААЛИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН АЖ АХУЙН НЭГЖИЙН ХӨТӨЛБӨР

(AUTHORIZED ECONOMIC OPERATOR)



УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

1. Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөр:



ДГБ-ын "Дэлхийн худалдааг аюулгүй байлгах болон хөнгөвчлөх багц стандарт"-ыг хэрэгжүүлэхээр Монголын гаалийн байгууллага 2006 онд үүрэг амлалт авч, гарын үсэг зурсан. Багц стандарт нь терроризмын аюул заналхийлэл, үндэстэн дамнасан гэмт хэрэг, холбогдох бусад хууль бус ажиллагаанаас бараа нийлүүлэлтийн сүлжээг хамгаалах, гааль-бизнесийн түншлэлийг хөгжүүлэх олон улсын стандартыг тогтоож өгсөн бичиг баримт юм.

Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах давуу талтай. Үүнд:

- ДГБ-ын багц стандартыг хэрэгжүүлэлтийг хангах;
- Гадаад худалдааны урсгалд гарах саад тотгорыг багасгах;
- Улс орны эдийн засгийн өсөлтийг хангах;
- Олон улсын тавцанд өрсөлдөх боломж, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх;



-Гаалийн байгууллагын хязгаарлагдмал нөөц боломжийг зөв ашиглан гаалийн хяналт шалгалтыг оновчтой, үр дүнтэй явуулах.



2. ИААН-ийн хөтөлбөр нь:



3. ИААН-ийн хөтөлбөрийн зорилго:



4. Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн төрөл:



5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх болсон үндсэн шаардлага:

- ДГБ-ын Худалдааг хөнгөвчлөх, Аюулгүй байдлыг хангах тухай багц стандарт, ДХБ-ын Худалдааг Хөнгөвчлөх Хэлэлцээрийг хэрэгжүүлэх үүрэгтэй.
- Томоохон экспортлогч импортлогч аж ахуйн нэгжүүдээс хүсэлт ирсэн.
- Монгол Улсын гадаад худалдааны гол түнш улс орнууд энэ хөтөлбөрт нэгдсэн. Эдгээр орны хөрөнгө оруулагч, худалдааны түншээс манай улсын гадаад худалдаа эрхлэгч нарт гаалийн итгэмжлэлтэй байх шаардлага тавьж эхэлсэн.

6. Энэ хөтөлбөрийн онцлог бөгөөд давуу тал:

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аж ахуйн нэгжид тодорхой шалгуур тавьж, шалгуур хангасан аж ахуйн нэгжид гаалийн байгууллагаас итгэл хүлээлгэж, гаалийн хяналт бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд тодорхой хөнгөлөлт үзүүлэх замаар гааль, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг дэмжсэн гаалийн байгууллагын худалдааг хөнгөвчлөх чиглэлд хэрэгжүүлэх арга ажиллагаа юм.

Гаалийн байгууллагын хувьд итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг сонгосноор эрсдэл багатай гэж үзэж тухайн аж ахуйн нэгжийн мэдүүлсэн бараанд хийх шалгалтаас тодорхой хувь хэмжээгээр чөлөөлөгдөнө. Ингэснээр зөвхөн